*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН НЯМДОРЖИЙН ЛУВСАНШАРАВЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилт 1. ЯАМНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 1.1. ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН, ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ, РАДИО ДАВТАМЖ, САНСРЫН ХОЛБОО, ИННОВАЦЫН БОДЛОГЫГ ТӨЛӨВЛӨХ, САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ"** | | | | | | | |
| 1.1 | Арга хэмжээ № 1.1. Салбарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэсэн цахим мэдээллийн самбар бий болгох, түүнийг бүрдүүлэх, ашиглах журам боловсруулж, батлуулах. | Батлагдсан журам | - | 1 | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын "хяналтын самбар" (dashboard)-т байрших ерөнхий мэдээлэл, байршуулах мэдээлэл, мэдээлэл хариуцагч байгууллага, мэдээлэл нийлүүлэх формат зэргийг агуулсан 95 жагсаалтын болон журмын төслийг газрын, нэгжийн дарга нарт танилцуулж нэмж сайжруулах үүрэг чиглэл авч харьяа салбар байгууллагуудаас харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн чиг үүрэгтэй холбогдуулан цугларсан мэдээлэл, мэдээллийн сангийн талаар тодруулж, холбогдох мэдээллийг ирүүлэх албан | 2024.01.01-2024.06.30 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бичгийг хүргүүлсний дагуу 3 байгууллагаас санал ирүүлснийг тусгав. | | |
| Зорилт 2. “ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ ХИЙНЭ” | | | | | | | |
| 2.1 | Арга хэмжээ 2.1. Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт техник, технологид суурилсан үйлчилгээний талаар судалгаа хийнэ. (дрон буюу нисгэгчгүй онгоц) | Судалгааны тоо | | | Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт техник, технологи болох нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон) судалгааг 5 үндсэн агуулгын хүрээнд боловсруулан БНСУ, Унгар, БНХАУ зэрэг орнуудын дрон ашиглаж буй үйлчилгээний талаар мэдээллийг орчуулж судлан эхний байдлаар дроны хэрэглээний өнөөгийн нөхцөл байдал, манай улсын хууль эрх зүйн орчин зэргийг танилцуулсан. | 2024.01.01-2024.06.30 | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | Арга хэмжээ 2.2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн олон улсын индекс, үзүүлэлтийн судалгааны сан бүрдүүлнэ. | Бүрдүүлсэн судалгааны сан | - | 1 | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн олон улсын индекс үзүүлэлтийн жагсаалт гаргаж, Монгол улсаас олон улсын байгууллагад хүргүүлдэг индексүүдийн мэдээллийг цуглуулж, судалгааний сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээллийг бүрдүүлж, судалгааны сан бүрдүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна. | 2024.01.01-2024.12.30 | 50% |
| **Зорилт 3. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ”** | | | | | | | |
| 3.1 | Арга хэмжээ 3.1. ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнах | Батлуулсан төлөвлөгөөний тоо, тайлангийн тоо | - | 1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, нэгжийн удирдлагаар батлуулж, батлагдсан загварын дагуу биелэлтийг гаргасан. | 2024.01.01-2024.12.30 | 90% |
| 3.2 | Арга хэмжээ 3.2. Чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад | Хүргүүлсэн биелэлтийн тоо | - | 1 | Бодлого, төлөвлөлтийн газарт хамаарах Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг сар бүр авч нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | | | | | | |
| 3.3 | Арга хэмжээ 3.3. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон албан бичиг, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх | Баримт бичгийн тоо | - | 1 | Нэгжийн даргаас цохсон 12 албан бичгийг шийдвэрлэж, 8 хариутай албан бичиг, 3 тушаалын төслийг боловсруулсан | 2024.01.01-2024.12.30 | 100% |
| 3.4 | Арга хэмжээ 3.4. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль | ХАСХОМ маягтын тоо,Ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийн тоо | - | 1 | Тайлант хугацаанд Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг тус тус хугацаанд нь мэдүүлж, баталгааны маягтыг баталгаажуулж Захиргааны эрх зүйн асуудал хариуцсан шинжээч (Б.Солонго)-д хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоомжийг хэрэгжүүлэх. | | | | | | |
| 3.5 | Арга хэмжээ 3.5. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь, чанартай гүйцэтгэх, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Үүрэг даалгаврын тоо | - | 1 | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/61 тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороонд чиг үүргийн хүрээнд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 2024.01.01-2024.12.30 | 100% |

## НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

| | Үүрэг даалгавар | Өгсөн объект | Биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ** | | | | | |
| 1. | "Шилэн төр, төрийн хурдан үйлчилгээ" зөвлөгөөнийг зохион байгуулах | Газрын дарга | Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуулиудын нэмэлт өөрчлөлтийн талаар "Шилэн төр, төрийн хурдан үйлчилгээ" сэдэвт уулзалт, зөвлөгөөнийг эрүүл мэнд, боловсролын албан хаагчдад танилцуулах уулзалтын бэлтгэл ажлыг ханган зохион байгуулсан. | 2024.01.01-2024.06.30 | 100% |
| 2. | Контентын агуулга бэлдэх | Газрын дарга | Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2024 оны Олон Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг "Fair and Responsible AI for consumers" уриа дор тэмдэглэхтэй холбогдуулан контентын агуулгыг | 2024.01.01-2024.06.30 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | боловсруулан Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газарт хүргүүлэв. | | |
| 3. | Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хэлэлцүүлгийг зохион байгуулах | Газрын дарга | Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийн 05 дугаар сарын 14-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор Мэдээллийн технологи, программ хангамж үйлдвэрлэлийн салбарын төр, хувийн хэвшлийн төлөөллүүдтэй холбогдож зар, мэдээлэл, зохион байгуулалтын арга хэмжээг авч оролцов. | 2024.01.01-2024.06.30 | 100% |
| 4. | Үнэлгээний хорооны нарийн бичгээр ажиллах | Хэлтсийн дарга | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/61 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны нарийн бичгээр ажиллаж, худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулсан. | 2024.10.01-2024.12.30 | 100% |
| 5. | Ажлын хэсгийн нарийн бичгээр ажиллах | Газрын дарга | Интернэтийн дундын холболтын журам боловсруулах Ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/30 дугаар тушаалаар байгуулж, 2024 оны 09 дүгээр сарын 05 болон 18-ны өдөр Ажлын хэсийн хурлыг зохион байгуулан тэмдэглэл хөтөлж, Ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн саналуудыг нэгтгэн танилцуулсан. | 2024.10.01-2024.12.30 | 100% |
| 6. | ЦХИХХ-ны сайдын гадаад албан уулзалтыг зохион байгуулах | Нэгжийн дарга | ЦХИХХЯ-ны сайд Ц.Баатархүү Канад Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хатагтай Сандра Шуфани болон Канадын ГХЯ-ны Энэтхэг-Номхон далайн бүс нутгийг хариуцсан худалдааны Ерөнхий төлөөлөгч Пол Топпил, Blackberry компанийн төлөөлөлч Мааз Ясин, Европын холбооноос Монгол Улсад суугаа Элчин сайд Ина Марчюлёните, Европын Комиссын Ази, Номхон далайн бүс нутаг болон Ойрх Дорнодыг хариуцсан Олон улсын түншлэлийн газрын захирал Петерис Устубс нарыг тус тус хүлээн авч уулзалтыг зохион байгуулж, ярианы тэмдэглэлийг холбогдох газарт хүргүүлэв. | 2024.10.01-2024.12.30 | 100% |

**ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 3.1 Олон улсын харилцаа холбооны байгууллага болон бусад холбогдох олон улсын зохион байгуулагдах сургалтад хамрагдах | Чиг үүргийн хүрээнд сургалтад хамрагдсан байна. | 1 | 1 | БНСУ-ын Шинэ бүтээлийг дэмжих нийгэмлэгийн Бодлогын лабораторийн туршлагаас суралцах цахим сургалтад 2024 оны 5 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд хамрагдав. | 2024.01.01-2024.06.30 | 100% |
| 2. | Арга хэмжээ 3.2 Байгууллагаас зохион байгуулсан хурал, зөвлөгөөнд хамрагдах. | Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад тухай бүрд хамрагдсан байна. | 1 | 1 | 1.Төрийн албаны зөвлөлөөс 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулсан "Албан хэргийг монгол болон кирилл бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих, эрх зүй технологийн орчин бүрдүүлж, бэлтгэх хангах" зорилтын хүрээнд 4 жил тутам явуулдаг "Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа"-ны явцын мэдээ, төрийн албан хаагч нарт зориулсан эх хэл, бичгийн мэдлэг, чадвар, дадлын номын танилцуулга сэдэвт 7:4:10 сургалтад хамрагдсан.<br>2.Төрийн албан хаагчийн Ёс зүйн хуулийн дагуу бүх шатны төрийн байгууллагын дэргэд Ёс зүйн дэд хороодын ажиллах журмыг танилцуулах 7:4:10 сургалтад хамрагдсан. | 2024.01.01-2024.12.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3.Авлигатай тэмцэх газраас “Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх” хүрээнд цахим сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 10:00-11:30 цагт | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ................................ /Н.ЛУВСАНШАРАВ/ ...2024/12.06...

*( Албан тушаал )* *(Гарын үсэг )* *( Нэр)* *( Огноо )*